

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ, ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ
АКТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН М.БЯМБАДОРЖИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024.12.04

Эрдэнэт

Тус хэлтсийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, захиргааны хэм хэмжээний акт хариуцсан мэргэжилтэн М.Бямбадорж миний бие аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн Б/20 дугаар тушаалаар уг албан тушаалд томилогдон ажиллаж байгаа бөгөөд томилогдсоноос хойш албан тушаалын тодорхойлолтод заасан зорилт, чиг үүргийн хүрээнд 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			1	2	3	4	5
НЭГ. "АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, МЭДЭЭЛЭХ, ТАЙЛАГНАХ ХҮРЭЭНД							
1	Арга хэмжээ №1.1 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам сахиулах ажлын үр дүн дээшилж, хуулийн хэрэгжилт хангагдсан байх	Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөө батлагдсан	Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2024 оны төлөвлөгөөнд орсон хэлтсийн хэрэгжүүлэх ажлын биелэлт, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, 2024 оны төлөвлөгөөний	Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар 2024.02.29-ний өдөр батлуулан Засаг даргын дэргэдэх хэлтэс, газар, агентлагуудад хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар нэгтгэн тус тус аймгийн ГХУСАЗСЗ-д хүргүүлэн, тайлагнаж ажилласан.	2024.02.09-2024.12.05	94.3%

				хэрэгжилтийн хувь 100%			
2	Арга хэмжээ № 1.2 Мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх	- Урьдчилан сэргийлэх ажлын хамралт - Мансууруулах төрлийн ургамлын устгах	- 14 ААН -105 га	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулж иргэд, ААН хамруулах	- Аймгийн ЦГ-тай хамтран “Мансуурал” хэсэгчилсэн арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангуулсан. - Мансууруулах төрлийн ургамлыг устгах “Устгал-2024” арга хэмжээний бэлтгэл ажлыг ЦГ-аас зохион байгуулан хэрэгжилтийг бүрэн хангасан. - Мөн Орхон аймаг дахь Гаалийн газраас санаачлан мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр 2024.09.18-ны өдөр Орхон, Булган аймгийн хууль хяналтын байгууллагуудын албан хаагчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулсан ба уг сургалтад оролцсон. - Аймгийн Цагдаагийн газраас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “АНЗААР” хэсэгчилсэн арга хэмжээг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 20-ний өдрийн хооронд зохион байгуулж ажилласан. Аймгийн Цагдаагийн газрын 2024 оны 12 дугаар сарын тоон мэдээллээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах гэмт	2024.02.09- 2024.12.05	100%

					хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 27.3% буурсан байна.		
3	Арга хэмжээ № 1.3 “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	90%	Хэрэгжилтийн хувь 100 хувь	Аймгийн Засаг даргын 2022 оны А/842 дугаар захирамжаар батлагдсан “Сургуулийн цагдаа” эргүүлийн ажиллах журмын хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Тухайлбал, “SCHOOL POLICE” сургууль орчмын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулахад өдөрт дунджаар 1-6-р ангийн 97-100 эцэг эх, асран хамгаалагч харгалзан дэмжигч нар хамтарч ажиллаж байна. Цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд жил бүр уламжлал болон зохион явуулдаг “Замын хөдөлгөөний цагаан толгой” ЕБС-ийн сурагчдын дунд “Ногоон гэрэл-Цагаан шугам” тэмцээнийг АИТХ, Цагдаагийн газар, Боловсролын газар хамтран зохион байгуулж нийт 500 гаруй хүүхэд багачууд оролцсон. Сургуулийн цагдаа хийж байж эцэг эх, асран хамгаалагч нар 6,8-н нэрийн дэлгүүрүүдэд хүүхдэд зарахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнд хяналт тавьж, дуу хоолойгоо хүргэсний үр дүнд ЭМГ, Боловсролын газрын улсын байцаагч нар шарсан дүпүг хураан авч, устгалд оруулсан. - Замын хөдөлгөөний дүрмийн талаар СӨБ, ЕБС-ийн сурагч,	2024.02.09- 2024.12.05	100%

					хүүхдүүдэд энгийн ойлголт, мэдэгдэхүүн өгөх зориулалт бүхий ном 2564 ширхэгийг хэвлүүлэн түгээсэн ба уг ажил орон нутгийн төсвөөс 9,999,600 төгрөг захирамжаар гарган, зарцуулсан. - Орхон аймгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын дунд жил бүр зохион байгуулдаг “ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЦАГААН ТОЛГОЙ 2024” тэмцээнийг 2024 оны 04 дүгээр сарын 12-ний өдөр Баян-Өндөр сум Залуучуудын соёлын ордонд зохион байгуулсан. Тэмцээнийг зохион байгуулахад шаардлагатай 10 сая төгрөгийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс шийдвэрлүүлэн 16 цэцэрлэгийн 160 хүүхдүүдийн дунд амжилттай зохион байгуулсан. - Цагдаагийн Ерөнхий газрын тэргүүн дэд даргын баталсан удирдамжийн дагуу “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл 2024” аяны хүрээнд “ШУГАМАН ЭРГҮҮЛ ХАР ХЭСЭГ” арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 15-аас 2024 оны 09 дүгээр сарын 10-ний өдөр хүртэл аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Аяны хүрээнд салбар төлөвлөгөө гаргаж аймгийн Засаг даргаар	
--	--	--	--	--	---	--

					батлуулан 5.000.000 төгрөгийг шийдвэрлүүлсэн. Мөн аймгийн ГХУСАЗСЗ-өөс 17.000.000 төгрөгийг шийдвэрлүүлэн Улсын чанартай А-1001 зам дээр Хурд хэмжиж байгаа цагдаагийн макет 4 ширхгийг, Анхаар хурд хэмжиж байна анхааруулах самбар 8 ширхгийг, Сигма анза Продакшнаар жолооч нарт зориулсан 5 төрлийн RELL бичлэгийг хийлгэн цахимд байрлуулан иргэдэд сурталчилсан.			
4	Арга хэмжээ № 1.4 Архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээг сайжруулах, албадан эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	Албадан эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	19	25 иргэнийг хамруулсан байна.	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр орж 7-30 хоногийн хугацаагаар баривчлагдсан хүчирхийлэгч болон хохирогч нарыг сэтгэл зүйн зөвлөгөө тусламж үйлчилгээнд хамруулан, гэр бүлд нь эргэн нэгтгэх зорилгоор хүчирхийлэгч, хохирогч 30 хүн, мөн архины хамааралтайн улмаас гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг 11 иргэнтэй ажиллаж ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө үйлчилгээг үзүүлэхээр "Итгэл дүүрэн гэр бүл" арга хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 7 дугаар сарын 25-ны өдрийн хооронд зохион байгуулсан. Уг арга хэмжээнд "Оюу" сэтгэц наркологи, клиникийн эмнэлэг болон "Мэдрэмж сэтгэл зүйн	2024.02.09-2024.12.05	90%	

					төв"-үүдтэй хамтран хэрэгжүүлэн ажилласан. Архины хамаралтай иргэдийг албадан эмчилгээнд хамруулах Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/348 дугаар захирамжаар "Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчилгээнд хамруулах"-д шаардагдах 5.000.000 /таван сая/ төгрөгийг шийдвэрлэж зарцуулсан болно. Мөн 2024.02.29-ний өдөр орон гэргүй, тэнэмэл иргэдийг нийгэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Хамтдаа тэмүүлэх гэрэлт ирээдүй" НҮТББ-ын үйл ажиллагаатай танилцаж, хяналт хийн ажилласан.		
5	Арга хэмжээ № 1.5 Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	90%	Хэрэгжилтийн хувь 100 хувь	Аймгийн хэмжээнд Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг Төсөл хөтөлбөрийн зардлын "Гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын зардлаас гарган ЦГ-т шилжүүлэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилласан.	2024.02.09-2024.12.05	100%
6	Арга хэмжээ № 1.6 Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлыг идэвхжүүлж, насанд хүрээгүй иргэдийн эрх	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	Хэрэгжилтийн хувь 100 хувь	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиг үүргийн хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдыг тухайн чиглэлээр	2024.02.09-2024.12.05	100%

	ашгийг хамгаалах ажилд чиг үүргийн хүрээнд оролцох			мэргэшүүлэх, мэдлэг, чадварыг сайжруулах чиглэлээр байгууллага бүр өөрийн дотоод сургалтын хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулж ажилласан ба аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ээс зарим чадавхжуулах сургалтыг санаачлан хэрэгжүүлсэн. Тухайлбал, Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга М.Мөнхбаярын 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн баталсан удирдамжийн дагуу “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”, “Хүүхэд хамгааллын тухай” хуулиудын хэрэгжилтийг хангах, салбар дундын уялдаа холбоог сайжруулах, түр хамгаалах байрны үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд анхаарах асуудал, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа, сайн туршлага, хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр холбогдох байгууллагуудын албан хаагчдыг чадавхжуулж, мэдээлэл, туршлага солилцох зорилгоор 2024 оны 11 дүгээр сарын 14-15-ны өдрүүдэд аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүн байгууллагуудын холбогдох албан хаагчид /нийт 12 албан		
--	---	--	--	---	--	--

					хаагч/ Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудад явж, хууль зүйн хороо, түр хамгаалах байрны үйлчилгээнд анхаарах асуудлын талаар сургалтад хамрагдаж, сайн туршлага, жишээг судлан, практик дээр танилцан ажилласан болно. - Аймгийн Хүүхдийн эрхийн эрхийн хууль зүйн хороог холбогдох хуулийн дагуу аймгийн ИТХ-тай зөвшилцсөний дагуу шинэчлэн байгуулаад байна.		
7	Арга хэмжээ № 1.7 Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг сахиулах үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг оролцуулах, хамтран ажиллах, дэмжих, мэргэжил, арга зүйгээр хангах	Хэрэгжилтийн хувь	Зохих ТББ, иргэдтэй хамтран ажилласан	Хамтран ажиллах гэрээт ТББ-уудын гэрээний хэрэгжилтийг 100% хангасан байна.	- Аймгийн БШУГ, ХГБХХГ-тай хамтран ЕБС-иудын ахлах ангийн 130 сурагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийн ажил хийсэн. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх иргэдэд зориулсан гарын авлага, тараах хуудас жилийн турш 5000 орчмыг бэлтгэн иргэдэд түгээж ажиллажээ. - Эдийн засгийн болон өмчлөх эрхийн эсрэг иргэдэд анхааруулга, зөвлөмж бүхий постер, мэдээллүүдийг бэлтгэн цахим хуудсаар түгээж ажилласнаас гадна аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй томоохон зах, худалдааны төвүүд, Баян-Өндөр сумын багуудын ажлын албаны байруудад зөвлөмж, анхааруулга /цахим залилан болон хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг	2024.02.09- 2024.12.05	100%

			агуулга бүхий/ наан байршуулж ажилласан. - 2024.09.01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн "Хүүхэд хамгааллын тухай хууль" (шинэчилсэн найруулга)-ийг сурталчлан таниулах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг чадавхжуулах чиглэлээр аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, Цагдаагийн газар, Боловсролын газартай хамтран батлагдсан удирдамжийн хүрээнд 2024.09.12-ны өдөр Хүүхдийн ордонд сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж ажилласан ба 80 гаруй хүн оролцсон. - 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, эрх зүйн асуудлаар зохих ойлголт, мэдээлэл өгч, цахим залилан, гэмт хэргээс хэрхэн сэргийлэх талаар зөвлөмж өгөх зорилгоор аймгийн хэмжээнд хандалт ихтэй томоохон группуудын админууд, Цагдаагийн газар, аймгийн ГХУСАЗС3-ийн ажлын алба, төрийн

					байгууллагуудын мэдээлэл, технологи хариуцсан ажилтнууд зэрэг холбогдох албан хаагчдад сургалт, мэдээлэл хийсэн ба уг сургалтад 60 гаруй хүн оролцсон. - Дээрхээс гадна насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Сэтгэл зүйн цогц боловсролын төв” НҮТББ, Замын хөдөлгөөний аюулгүй байдал, гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх чиглэлээр “Цагаан шонхорын жигүүр” ТББ-тай хамтран ажиллаж байгаа.		
8	Арга хэмжээ № 1.8 Хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах байрны үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил, арга зүйгээр хангах.	Туслалцаа үзүүлсэн иргэдийн тоо, үзүүлсэн үйлчилгээний чанар	Зохих хяналт тавьж ажилласан. 2023 онд 67 хүн тус байраар үйлчилгээ авсан	Түр хамгаалах байраар үйлчилгээ авсан хүмүүс “даван туулагч” болгох зохих үйлчилгээг хүргэсэн байна.	Хэлтсийн даргын 2024.03.21-ний өдрийн 05/897 тоот “Ажлын чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт Түр хамгаалах байрны үйлчилгээнд баримтлах хууль, журам, стандартын талаар чиглэл, зөвлөмж өгсөн. Мөн тус байрны үйлчилгээнд тогтмол хяналт тавьж, сар бүр үйлчлүүлсэн иргэдийн статистик мэдээллийг авч ажиллаж байна. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байраар насанд хүрсэн үйлчлүүлэгч-16, насанд хүрээгүй үйлчлүүлэгч-60, нийт-	2024.02.09-2024.12.05	100%

				76 хүн хүлээн авсан. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байранд Гэр бүлийн болон бусад төрлийн хүчирхийллийн хохирогч болж ирж буй үйлчлүүлэгчид үзүүлж буй үйлчилгээ түр хамгаалах байрны дүрэм танилцуулах, кейс нээх, хамтарсан төлөвлөгөө боловсруулах, хамтарсан багтай хамтран ажиллаж, нууцын гэрээ байгуулах, Түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх журмын дагуу холбогдох маягтуудыг хөтөлж кейсын бүрдэл хангаж ажиллаж байна. Түр хамгаалах байраар үйлчилгээ авсан нийт 76 хүний хүчирхийллийн хэлбэрээр нь авч үзвэл: гэр бүлийн хүчирхийлэл-8, бие махбодийн хүчирхийлэл-3, бэлгийн хүчирхийлэл-4, үл хайхрах хүчирхийлэл-10, сэтгэл санааны хүчирхийлэл-2 байна. Үйлчлүүлэгч хүлээн авч үзүүлсэн үйлчилгээг ангилвал: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ-16, эрх зүйн туслалцаа-13, Сэтгэл зүйн үйлчилгээ-13, Хүүхэд хамгааллын үйлчилгээ-38 үзүүлсэн байна.	
--	--	--	--	--	--

9	Арга хэмжээ № 1.9 Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж тогтоох, арилгах, тухайн жилд өссөн дүнтэй гарсан гэмт хэрэг, зөрчлийг бууруулах ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх.	Гэмт хэргийн гаралт буурсан хувь, үзүүлэлт	2023 онд аймгийн хэмжээнд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 73% нь Хүний эрүүл мэндэд учруулсан гэмт хэрэг, залилах, хулгайлах гэмт хэргүүд байна	Өсөлттэй байгаа гэмт хэргийн гаралт буурсан үзүүлэлттэй байна.	Аймгийн Цагдаагийн газраас аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын мэдээг сар тутам авч, дүн шинжилгээ хийн ажиллаж байгаа бөгөөд тайлангийн хугацаанд өсөлттэй байгаа зарим гэмт хэргийн чиглэлээр тодорхой хэсэгчилсэн болон нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Тухайлбал, ЦГ-тай хамтран 14 хэсэгчилсэн арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг хангасан. Аймгийн хэмжээнд залилах, хулгай, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргүүд өсөлттэй байна. Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Залилагч нарт боломж бүү олго” хэсэгчилсэн арга хэмжээ, цахимаар залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ, сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулсан. Тухайлбал, ЕБС-иудын нийт 500 орчим сурагчдад, төрийн байгууллагуудын 100 гаруй албан хаагчдад сургалт, мэдээлэл хийн, иргэдэд 1500 гаруй гарын авлага тараан ажилласан байна. Ингэснээр 11 дүгээр сарын байдлаар зарим төрлийн гэмт хэрэг буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал, 2024 оны 11 дүгээр сарын байдлаар өнгөрсөн оны	2024.02.09-2024.12.05	100%
---	---	--	---	--	--	-----------------------	------

					мөн үетэй харьцуулахад аймгийн хэмжээнд хүүхэд оролцсон гэмт хэрэг 31.3%, дээрэмдэх гэмт хэрэг 13.3%, хүүхдийн эсрэг гэмт хэрэг 77.8%, орон байрны хулгай 32.3%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.		
10	Арга хэмжээ № 1.10 Орхон аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлийн ажлыг холбогдох газруудтай хамтран гүйцэтгэх	Гэмт хэрэг, зөрчлийн буурсан үзүүлэлт, хувь	Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөн ий холбогдох заалтын хэрэгжилтийг хангасан	Гэмт хэрэг, зөрчлийг 5% бууруулсан байна.	Орхон аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлийн ажлыг аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган холбогдох газруудад аймгийн Засаг даргын албан бичгээр хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан, биелэлтийг авч нэгтгэн танилцуулан ажилласан. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аймгийн хэмжээнд хүүхэд оролцсон гэмт хэрэг 31.3%, дээрэмдэх гэмт хэрэг 13.3%, хүүхдийн эсрэг гэмт хэрэг 77.8%, орон байрны хулгай 32.3%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.	2024.02.09-2024.12.05	90%
11	Арга хэмжээ № 1.11 Сумдын болон төрийн байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдлага, арга зүйгээр хангах, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилтийн үр дүн, хувь	Зохих хяналт тавьж ажилласан	Сумдын ГХУСАЗСЗ-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, хамтран	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж болон Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Орхон аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллахаар байгуулсан гэрээ, аймгийн	2024.02.09-2024.12.05	100%

				ажиллах, хэрэгжилтийн хувь 100	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөө, аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдийг үндэслэн 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр аймгийн Засаг даргаар аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, Засаг даргын дэргэдэх харьяа агентлаг, байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг ханган, хяналт тавин ажиллаж, биелэлтийг гаргуулан авч танилцуулан ажилласан.		
ХОЁР. ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ШИНЭЭР БАТЛАГДСАН АКТЫГ ХЯНУУЛЖ, УЛСЫН НЭГДСЭН БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД							
12	Арга хэмжээ № 2.1 Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг ХЗДХЯ-нд хянуулж улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулах	Хуулийн дагуу хянуулж, бүртгүүлсэн захиргааны хэм хэмжээний актын тоо	Аймгийн хэмжээнд нийт 8 захиргааны хэм хэмжээний акт баталж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн	Аймгийн хэмжээнд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулахтай холбоотой захиргааны хэм хэмжээний актыг холбогдох хуульд нийцүүлэн	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл 9.2 дахь хэсгийг үндэслэн аймгийн хэмжээнд "Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах, төлбөрийн хувь хэмжээ болон тээврийн хэрэгсэл түр зогсохыг хориглох гудамж, зам, хамрах хүрээ, үйлчлэх цагийн хязгаарыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр тогтоох захиргааны хэм хэмжээний актын төслийг Захиргааны	2024.02.09- 2024.12.05	95%

44

				батлуулж, бүртгүүлнэ	ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, нөлөөллийн шинжилгээ, санал авах ажил хийн, иргэдтэй 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-ын Зөвлөлийн хуралдаанаар тус тус 1 удаа хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан. Тус хэм хэмжээний актыг 12-р сардаа батлуулахаар ажиллаж байна.		
13	Арга хэмжээ № 2.2 Сумдын захиргааны хэм хэмжээний актыг хянуулж бүртгүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах	Захиргааны хэм хэмжээний актыг хуулийн дагуу хянуулж мөрдүүлсэн байна	Сумдад тухай бүр арга зүй өгч ажилласан	Сумдын захиргааны хэм хэмжээний актыг хянуулж бүртгүүлэх үйл ажиллагаанд тухай бүр хяналт тавьж ажиллах	Сумдад захиргааны хэм хэмжээний актыг холбогдох хуулийн дагуу боловсруулж, бүртгүүлэх ажлыг хийх асуудлаар албан бичгээр чиглэл өгсөн. Тайлангийн хугацаанд сумдаас хэм хэмжээний акт шинээр гаргаагүй болно.	2024.02.09- 2024.12.05	100%
ГУРАВ. ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН, ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫГ ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ХҮРЭЭНД							
14	Арга хэмжээ № 3.1 Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийг хангах чиглэлээр холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх, тайлагнах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	Хэрэгжилтийн хувь 60%	ШӨХТГ-тай хамтран 2024.04.09-нд аймгийн хэвэлэл мэдээллийн байгууллагуудын ажилтнуудад сонгуулийн сурталчилгаатай холбоотой анхаарах асуудлаар зөвлөмж өгч, сургалтын ажлыг зохион байгуулсан. Зах зээлийн өрсөлдөөнийг хянан	2024.02.09- 2024.12.05	90%

				зохицуулах чиглэлээр хяналт шалгалтыг орон нутагт зохион байгуулах, өрсөлдөөний хуулийг сурталчлах үйл ажиллагаанд шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг төсөл хөтөлбөрийн зардлаас гарган шийдвэрлэсэн. Тус газрын орон нутаг дахь байцаагчтай байгуулсан хөлсөөр ажиллах гэрээг цуцлах мэдэгдлийг аймгийн Засаг даргаас 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 01/2763 тоот албан бичгээр хүргүүлж улмаар 2024.11.18-ны өдрийн Б/34 дугаар захирамжаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлаад байгаа болно.		
--	--	--	--	---	--	--

15	Арга хэмжээ № 3.2 Хэрэглэгчээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт явуулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ-тай хамтарч ажиллах, дэмжлэг үзүүлэх.	Өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь, хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчил, зөрчлийг арилгуулсан үр дүн	Ирсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж ажилласан	Ирсэн өргөдөл, гомдлыг тухай бүр хуулийн хугацаанд шийдвэрлэх	Хэрэглэгчдийн эрх, ашгийг хамгаалах ажлын хүрээнд “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг” НҮТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан, үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Тухайлбал, дээрх чиглэлээр иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх, сургалт, урьдчилан сэргийлэх ажил, хяналт шалгалт, нөлөөллийн ажил зохион байгуулахад шаардагдах 8,000,000 (найман сая) төгрөгийг Төсөл хөтөлбөрийн зардлын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үйл ажиллагааны зардлаас гаргуулан зарцуулсан. Мөн гэрээгээр ажил хамтран гүйцэтгэж буй ТББ-аас жилийн тайлан, мэдээллийг авч, гэрээг дүгнэн ажилласан.	2024.02.09- 2024.12.05	100%
ДӨРӨВ. ЗАХИРГААНЫ БОЛОН ИРГЭНИЙ МАРГААНТАЙ АСУУДАЛД ЧИГ ҮҮРГИЙН ДАГУУ ШҮҮХЭД ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧӨӨР ОРОЛЦОХ, АЖЛЫН ХЭСЭГ, ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ОРОЛЦОЖ АЖИЛЛАХ ХҮРЭЭНД							
16	Арга хэмжээ № 4.1 Аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрыг шүүх болон бусад этгээдийн өмнө төлөөлөх, хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах	Аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрыг шүүх болон бусад этгээдийн өмнө төлөөж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль болон итгэмжлэлийн	Итгэмжлэлийн дагуу тухай бүр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож ажилласан	Олгосон итгэмжлэлийн тоогоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, байгууллагын эрх ашгийг ханган, хамгаалсан байна.	Аймгийн Засаг даргын итгэмжлэлээр Орхон аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 3 /Сод-Өргөө ХХК, Төрийн банк ХК, Чэс ХХК-д, иргэн Б.Батсайханд тус тус холбогдох/, Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 5 хэрэгт /Наяд констракшн ХХК, Хэрлэн зураглал ХХК, Ээлт-Өлгий ХХК-д холбогдох/, аймгийн ЗДТГ-ын даргын	2024.02.09- 2024.12.05	100%

16/4

		хүрээнд оролцож, зохих эрх ашгийг ханган хамгаалах			итгэмжлэлээр 1 /Урагшлах ХХК-д холбогдох/ хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль болон итгэмжлэлийн хүрээнд оролцож, зохих эрх ашгийг ханган ажиллаж байна. Үүнээс аймгийн Засаг даргыг хариуцагчаар татсан, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах нэхэмжлэлийн шаардлага бүхий Сод-Өргөө ХХК, Төрийн банк ХК-ийн нэхэмжлэлтэй хэргийг Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн байна.		
17	Арга хэмжээ 4.2 Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга болон эрх бүхий этгээдийн шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг, комисст ажиллах	Ажилласан ажлын хэсгийн тоо, хэрэгжүүлсэн ажлын үр дүн	Холбогдох ажлын хэсэг, комисст томилогдон ажилласан	Холбогдох хууль, шийдвэрийн хүрээнд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцож, ажлын хэсгийн гишүүний хувиар чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлсэн байна	- Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд гишүүнээр томилогдсон ба тус хорооны анхдугаар хуралд оролцож, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулахад оролцож хэрэгжилтийг ханган ажилласан. Хороонд ирсэн 1 өргөдөл, гомдлыг судалж шийдвэрлэсэн. - Мөн Баян-Өндөр сумын хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт	2024.02.09- 2024.12.05	100%

					хороонд Захиргааны байгууллагын төлөөлөл болон оролцож ажилласан. - Үүнээс гадна аймгийн Засаг даргын захирамж болон ЗДТГ-ын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт тухай бүр оролцож ажиллаж байна.		
18	Арга хэмжээ 4.3 Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах үйл ажиллагааг шийдвэрдэх "Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөл"-ийн өдөр тутмын ажлыг хариуцан хэрэгжүүлэх.	Холбогдох хууль, журмын дагуу Зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зөвлөлөөс гаргасан тогтоолын тоо, шийдвэрлэлтийн хувь	Тухай бүр Зөвлөлөөс тогтоол гарган хураан авсан эд зүйлийг устгах, худалдан борлуулах зөвлөлүүдэд шилжүүлэн шийдвэрлүүлсэн	Холбогдох журмын дагуу Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг ханган, зохих шийдвэрийн дагуу ажиллах	"Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөл"-ийн 2024 оны эхний хагас жил болон жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг гарган зөвлөлийн даргад, Прокурорын газарт тус тус танилцуулсан. Тус Зөвлөл нь 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар тус зөвлөлд эрх бүхий байгууллагуудаас /Аймгийн Цагдаагийн газар, ШШГТ, БОАЖГ/ ирүүлсэн нийт 52 албан бичиг, хүсэлтээр эд зүйл, хөрөнгийг хүлээн авч бүртгэлд оруулж, Зөвлөл зохих журмын дагуу 17 тогтоол гарган, хүлээн авсан эд зүйл, хэрэгслийг зохих комисс руу шилжүүлж шийдвэрлэсэн бөгөөд тухай бүр эд зүйл хүлээн авсан албан бичиг, шийдвэрийг тухайн байгууллагуудад хүргүүлж ажилласан байна. Одоогийн байдлаар 4,395,890 /дөрвөн сая гурван зуун ерөн таван мянга, найман зуун ерөнтөгөр/-ийг Төрийн	2024.02.09-2024.12.05	100%

62

сангийн Ор. Хүү торгуулийн орлого 100210000988 дансанд төвлөрүүлсэн байна

ТАВ. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

19	Арга хэмжээ 5.1 ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж албан тушаалтанд хүргүүлэх	Хэрэгжилтийн хувь	-	Биелэлтийг жилийн эцсийн байдлаар гаргаж тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.	Хариуцсан чиглэлийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг АТТ-тай нийцүүлэн боловсруулж батлуулан, хэрэгжилтийг ханган ажилласан ба биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнасан. Мөн хариуцсан чиглэлээр бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь тухай бүр гарган холбогдох нэгж, газруудад хүргүүлсэн.	2024.02.09-2024.12.05	100%
20	Арга хэмжээ 5.2 Хариуцсан чиг үүргийн дагуу байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлыг тогтоосон хугацаанд судалж шийдвэрлэх	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, албан бичгийн хариу хугацаандаа хэрэгжсэн байх	-	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, албан бичгийн хариу хугацаандаа хэрэгжсэн байна	Тайлангийн хугацаанд иргэдээс ирүүлсэн нийт 32 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд үүнээс ЗГ-ын “1111” төвд өгсөн нийт 8 гомдлыг шийдвэрлэжээ.	2024.02.09-2024.12.05	100%
21	Арга хэмжээ 5.3 Төрийн албаны тухай хууль болон төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрэм, журам, бусад холбогдох стандартыг мөрдөн хэрэгжүүлэх	Ёс зүйн хэм хэмжээ, холбогдох хууль, журмын зөрчилгүй ажилласан байдал	Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрэм, журам, бусад	Ёс зүйн хэм хэмжээ, холбогдох хууль, журмын зөрчилгүй ажилласан байна.	Үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдөж, ёс зүй, сахилга, хариуцлага зөрчсөн зөрчил гаргаагүй болно.	2024.02.09-2024.12.05	100%

			холбогдох стандартыг мөрдөн ажилласан.				
22	Арга хэмжээ 5.4 Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн баримт бичгийн төсөл төлөвлөх, архивын нэгж бүрдүүлэх, байгууллага, нэгжийн өдөр тутмын дотоод үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах	Хэрэгжилтийг ханган ажиллана	-	Хэрэгжилтийг ханган ажиллана	Боловсруулж буй мэдээлэл, тайлан, албан бичиг зэрэг хөтөлж буй бичиг баримтдаа Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартыг мөрдлөгө болгон ажиллаж байна.	2024.02.09- 2024.12.05	100%
23	Арга хэмжээ 5.5 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон Авилгын эсрэг хууль тогтоомжийг мөрдөх, хэрэгжилтийг хангах	Эрх бүхий албан тушаалтанд хувийн ашиг сонирхлын зөрчил үүсэх мэдэгдэл, мэдүүлэг өгсөн байдал	-	Ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажилласан байна.	Үйл ажиллагаандаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон Авилгын эсрэг хууль тогтоомжийг мөрдөж ажилласан. Мөн Авлигатай тэмцэх газрын 2024.09.17-ны өдрийн 08/14814 дугаар "Сургалтад оролцуулах тухай" албан бичгийн дагуу тус газрын Олон нийтийн төвд 2024 оны 09 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ын сургалтад хамрагдаж ажиллалаа.	2024.02.09- 2024.12.05	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	Аймгийн хэмжээнд тэсэрч дэлбэрэх бодис, химийн хорт болон аюултай бодисын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран хяналт, шалтгалтыг төлөвлөн хийх	Илрүүлсэн зөрчил, арилгуулах арга хэмжээ авсан байдал	-	Илрүүлсэн зөрчил, дутагдлыг арилгуулсан байна	Энэ хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран тайлангийн хугацаанд 2 удаагийн хяналт, шалгалтыг зохион байгуулж ажилласан. Тодруулбал, Аймгийн ГХУСАЗСЗ-ийн дарга Д.Мөнхбатын 2024.04.09-ний өдөр баталсан "Химийн хортой болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт, шалгалт хийх" ажлын удирдамжийн дагуу холбогдох мэргэжлийн байгууллагуудын хамтарсан шалгалтыг 2024.04.10-2024.04.16-ны өдрийн хооронд зохион байгуулж, зохих тусгай зөвшөөрөл бүхий 9 аж ахуйн нэгж, байгууллагуудад холбогдох хууль, стандартын хэрэгжилтийн байдалд хяналт тавьж, байгаль орчинд сөргөөр	2024.04.10- 2024.04.16- 2024.10.22- 2024.10.24	100%

82

					нөлөөлөх, гамшиг аюулаас урьдчилан сэргийлэх, тэсрэх бодис, химийн бодис алдагдаж, үрэгдэх, зориулалтын бусаар ашиглагдахаас урьдчилан сэргийлж хяналт, шалгалт хийж нийт нийтлэг 11 зөрчил, дутагдлыг илрүүлэн арилгуулах арга хэмжээг авсан. Мөн дээрх шалгалтын үед өгөгдсөн албан шаардлагын биелэлтийг хянах гүйцэтгэлийн шалгалтыг Терроризмтэй тэмцэх ажлыг зохицуулах зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, дэд хурандаа Д.Энхтүвшингийн баталсан удирдамжийн дагуу 2024.10.22-24-ний өдрүүдэд зохион байгуулж дүнг хэлтсийн даргад илтгэх хуудсаар танилцуулсан.		
2	Аймгийн ГХУСАЗСЗ болон ЕБС-иудтай байгуулсан хариуцлагын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих.	Илрүүлсэн зөрчил, арилгуулах арга хэмжээ авсан байдал	Гуравласан гэрээ байгуулагдсан	Гэрээний хэрэгжилтийг дүгнэн, хяналт хийсэн байна.	Хариуцлагын гэрээ байгуулсан нийт 24 ЕБС-иудад хяналтаар ажиллаж нийтлэг 9 зөрчил, дутагдлыг арилгах талаар зөвлөмж, мэдээлэл өгч ажилласан.	2024.05.09-2024.05.14	100%

3	Сумдын Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлд хяналт хийх	Илрүүлсэн зөрчил	-	Өөрт хуваарилагдсан захирамжийн хууль зүйн үндэслэлд хяналт хийж, дүнг танилцуулсан байна.	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2023 оны А/320-А/373, Жаргалант сумын 2023 оны А/136-А/315 дугаар захирамжийн хууль зүйн үндэслэл болон албан хэрэг хөтлөлтийн стандарт, шаардлага хангаж байгаа эсэхийг хянаж, дүн, илтгэх хуудсыг танилцуулж ажилласан.	2024.03.01.- 2024.03.20	100%
4	ЕБС-иудад хадгалагдаж буй устгах шаардлагатай химийн хорт болон аюултай бодисын судалгааг гарган танилцуулах	Судалгааг хийж, цаашид шийдвэрлэх ажлын санал танилцуулсан байдал	Суурь судалгаа хийгдэж байсан	Судалгааг шинэчлэн танилцуулсан байна.	БШУГ-тай хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Ерөнхий боловсролын нийт 21 сургуулийн хэмжээнд хичээл, сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байсан, устгах шаардлагатай болсон химийн бодисын судалгааг шинэчлэн, нэгтгэж танилцуулсан.	2024.04.22- 2024.04.26	100%
5	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн ойролцоох амралтын газруудад эргүүл, хяналтын ажлыг зохион байгуулж, мэдэгдэх хуудас өгөх.	Эргүүл, хяналтаар ажилласан тоо	Аймгийн Засаг даргын 2024 оны А/376 дугаар "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох тухай"	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх "мэдэгдэх хуудас" бэлтгэн зохих газруудад өгч, урьдчилан сэргийлж	Аймгийн ЦГ болон БШУГ-тай хамтран Ерөнхий боловсролын болон Их, Дээд сургуулиудын эрдмийн баяр, Хүүхдийн баяр, Монгол Улсын Их Хурлын 2024 оны Ээлжит сонгуулийн санал авах өдөр, Үндэсний их баяр наадам зэрэг бүх нийтээр амрах, нийтээр тэмдэглэх	2024.05.28- 2024.05.30	100%

			захирамж гарган иргэд, ААНБуудад түгээсэн.	ажилласан байна.	баярын болон тэмдэглэлт өдрүүд тохиож байгаатай холбогдуулан гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн ойролцоох нийт 12 амралтын газруудад эргүүл, хяналт хийж, холбогдох зөвлөмж, “мэдэгдэх хуудас” өгч ажилласан.		
6	Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэгчдийн чиглэлээр хяналт, шалгалт хийх	Илрүүлсэн зөрчил, арилгуулах арга хэмжээ авсан байдал	-	Илрүүлсэн зөрчил, дутагдлыг арилгуулсан байна	Аймгийн ГХУСАЗСЗ-ийн дарга Д.Мөнхбатын баталсан удирдамжийн дагуу 2024.11.07-08-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч, барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаа нь холбогдох хууль, журамд заасан тавигдах шаардлага, стандартыг хангаж буй эсэхэд хяналт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор хийгдсэн хяналт, шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцож ажиллан дүнг	2024.11.07- 2024.11.09	100%

					илтгэх хуудсаар танилцуулсан. Шалгалтаар нийтлэл 5 зөрчил илрүүлж, 13 иргэн, 3 ААНБ-д мэдэгдэл өгч зөрчлийг арилгуулсан.		
--	--	--	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			3	4	5	6	7
1	Мэргэшүүлэх багц сургалт болон албан тушаалын чиг үүрэгт хамаарах чиглэлээр холбогдох газруудаас зохион байгуулсан сургалтуудад хамрагдах	Мэдлэг, ур чадвар сайжирсан байдал	Удирдлагын академийн дунд хугацааны сургалтыг дүүргэсэн	Мэдлэг, ур чадвараа сайжруулан, тасралтгүй хөгжүүлж ажилласан байна.	Аймгийн ЗДТГ болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан сургалтуудад оролцож ажилласан. Тухайлбал, Чанарын менежментийн тогтолцооны “Дотоод аудитор”-ын 3 өдрийн сургалт, “Үр дүнд суурилсан төлөвлөлт” сэдэвт 2 өдрийн сургалт, ХЗДХЯ-ны Үндсэн хууль, Захиргааны ерөнхий хуулийн цахим сургалт, ШШГЕГ-аас хийсэн “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тотоох тухай” сэдэвт сургалт, Удирдлагын академийн “Монгол Улсын хөгжлийн бодлого, хэрэгжилт: Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл” сэдэвт сургалтад тус тус хамрагдсан	2024.02.09-2024.12.05	100%

					сертификат авсан. Мөн ТАЗ-ийн 7:4:10 сургалт болон бусад сургалтуудад тухай бүр оролцсон.		
2	Салбарын үйл ажиллагаанд баримтлах хууль тогтоомжийн шинэчлэлийг тогтмол судлах	Мэдлэг, ур чадвар сайжирсан байдал	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг тухай бүр үйл ажиллагаандаа баримтлан ажилласан.	Мэдлэг, ур чадвараа сайжруулан, тасралтгүй хөгжүүлж ажилласан байна	Хариуцсан чиглэл, үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, журам, стандарт, эрх зүйн хэм хэмжээний шинэчлэлийг тухай бүр судалж, баримтлан ажиллаж байна.	2024.02.09-2024.12.05	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил,
захиргааны хэм хэмжээний акт хариуцсан
мэргэжилтэн
(Албан тушаал)

М.БЯМБАДОРЖ /  /

(Нэр, гарын үсэг)

2024 оны 12 дугаар сарын 04-ний
өдөр

(Огноо)

88